

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 04 сарын 04-ны өдөр

Дугаар... БА-039/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул Дүүргийн 18 дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын 1 давхар нэмэх 31.5м*15.0м хүчин чадал бүхий бага ангийн хүүхдийн чийрэгжүүлэх хөгжөөнт тоглоомын танхимын зориулалттай өргөтгөлийн барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/06/25 огноо, 0000437 дугаар, БА32024/0213;

2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар К-30/22;

2.3 Захиалагч: Ерөнхий боловсролын Хобби сургууль ХХК оноосон нэр, 9011498106 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5890373 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо, Оргил Стадион, Удирдлагын академи гудамж 56, 76099119 холбоо барих утас, info@hobbyschool.edu.mn цахим хаяг;

2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Хийт констракшн ХХК оноосон нэр, 9011215049 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5339693 регистрийн дугаар, БУ11-350/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо, Чингүнжавын гудамж, 47/2-2тоот, 88889248, 99104742 холбоо барих утас;

2.5 Барилга байгууламжийн Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй;

2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Конар ХХК оноосон нэр, 9011579010 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6019463 регистрийн дугаар, ЗТ19-581/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, Жуулчны гудамж-42, Капитал төв, 1105 тоот, 99193158, 70113158 холбоо барих утас;

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Ерөнхий боловсролын Хобби сургууль” ХХК оноосон нэр, 9011498106 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5890373 регистрийн дугаар,

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо, Оргил Стадион, Удирдлагын академи гудамж 56, 976-76099119 холбоо барих утас, info@hobbyschool.edu.mn цахим хаяг;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан;

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 бага төвөгшилтэй ангиллын 1 давхар нэмэх 31.5м*15.0м хүчин чадал бүхий бага ангийн хүүхдийн чийрэгжүүлэх хөгжөөнт тоглоомын танхимын зориулалттай өргөтгөлийн барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;


б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.



3.4 Комиссын акт хуудас, хуралдааны тэмдэглэл хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Бага төвөгшилтэй ангиллын 1 давхар нэмэх 31.5м*15.0м хүчин чадал бүхий бага ангийн хүүхдийн чийрэгжүүлэх хөгжөөнт тоглоомын танхимын зориулалттай өргөтгөлийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, Ерөнхий боловсролын Хобби сургууль ХХК-ийн захиалгатай Бага ангийн хүүхдийн чийрэгжүүлэх хөгжөөнт тоглоомын танхимын өргөтгөлийн барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн дарга




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
“Ерөнхий боловсролын Хобби сургууль” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 18 ДУГААР ХОРОО, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХОББИ
СУРГУУЛЬ ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ БАГА АНГИЙН ХҮҮХДИЙН ЧИЙРЭГЖҮҮЛЭХ
ХӨГЖӨӨНТ ТОГЛООМЫН ТАНХИМЫН ЗОРИУЛАЛТТАЙ ӨРГӨТГӨЛИЙН
БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Хан-Уул Дүүргийн 18 дугаар хороо, Ерөнхий Боловсролын Хобби Сургууль ХХК-ийн захиалгатай 1 давхар нэмэх 31.5м*15.0м, бага ангийн хүүхдийн чийрэгжүүлэх хөгжөөнт тоглоомын танхимын зориулалттай өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 3 дугаар давхарын хурлын танхимд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 11:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13:00 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Хуралд:

- | | | |
|----|---|--------------|
| 1 | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Батчимэг |
| 2 | Комиссын нарийн бичгийн дарга: Ерөнхий боловсролын Хобби сургууль ХХК-ийн Гүйцэтгэх захирал | Г.Цэлмүүн |
| 3 | Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Ж.Жүгдэрмаа |
| 4 | Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 5 | Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | Г.Уртнасан |
| 6 | Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн ХХХ-ийн дарга | Д.Сүхбат |
| 7 | Эс Жи И Эн ХХК Цахилгаан түгээх компанийн Ерөнхий инженер | Б.Пүрэв |
| 8 | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн мэргэжилтэн | Ц.Дагвадорж |
| 9 | Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Д.Болормаа |
| 10 | Нийслэлийн онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, ахмад | Б.Дөл-Эрдэнэ |
| 11 | Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч | Я.Чулуун |
| 12 | Ерөнхий боловсролын Хобби сургууль ХХК-ийн Ашиглалтын инженер | Р.Содномдорж |

- | | | |
|----|---|--------------|
| 13 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Б.Болормаа |
| 14 | Зураг төслийн КОНАР ХХК-ийн захирал | Ж.Даваасүрэн |
| 15 | Гүйцэтгэгч Хийт констракшн ХХК-ийн захирал | А.Доржсүрэн |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, Ерөнхий Боловсролын Хобби Сургууль ХХК-ийн захиалгатай 1 давхар нэмэх 31.5м*15.0м хүчин чадал бүхий бага ангийн хүүхдийн чийрэгжүүлэх хөгжөөнт тоглоомын танхимын зориулалттай өргөтгөлийн барилгыг барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Ашиглалт хариуцах Ерөнхий боловсролын Хобби сургууль ХХК-ийн Ашиглалтын инженер **Р.Содномдорж:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч Хийт констракшн ХХК-ийн захирал **А.Доржсүрэн:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч КОНАР ХХК-ийн захирал **Ж.Даваасүрэн:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч Ерөнхий боловсролын Хобби сургууль ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Г.Цэлмүүн:**

- Цахилгааны шит дотор кабель хаягжуулалт хийх
 - Халаалтын радиторын урд хаалт хийх
 - Салхивч, халаалт цахилгааны ил далд акт өгөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Болормаа:**

- Орох хэсгийн налуулалтыг стандартын дагуу хийх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**

ХЯНАЛ
Барилга байг
ор

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан нормчлолын сангийн төлбөр төлөх; Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Я.Чулуун:**

- Архивд баримт бичиг бүрдүүлж өгөх жагсаалтын дагуу баримтаа бүрдүүлэх
 - Ажлын зураг болон үндсэн баримтын эх хувийг улсын архивд хүлээлгэж өгөх
 - Хувийн хэрэг болон үндсэн баримтад дотоод товъёог үйлдэж, хуудас дугаарлаж заавар журмын дагуу цэгцлэх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх газрын Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, ахмад **Б.Дөл-Эрдэнэ:**

- Аврах зам гарц шатны хонгил чөлөөтэй болгох
 - Гал унтраах даралтын хоолойн техникийн шаардлага, гал түймэр унтраах хоолой, тотго, MNS6576:2016 дагуу бардонов тотго хийж байрлуулах
 - Магадлал орсон дүгнэлтийг нөхөж үзүүлэх
 - Хөгжөөнт тоглоомын танхимаас орж гарах шатыг өөрчилж пандус болгосон талаар захиалагч гүйцэтгэгч автор дүгнэлт албан бичиг гаргаж өгөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа:**

- Тухайлсан саналгүй.
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Эс Жи И Эн ХХК Цахилгаан түгээх компанийн Ерөнхий инженер **Б.Пүрэв:**

- Цахилгааны өрөөнд галын хортой болгох
 - Тэжээлийн кабельд бирк хаягжилт хийх
 - Гүйцэтгэлийн зураг схем хүлээлгэн өгөх /Захиалагчид/
 - Ерөнхий контурт холбосон далд ажлын акт үзүүлэх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж:**

- Тухайлсан саналгүй;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат:**

- Тухайлсан саналгүй;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Үндсэн барилгын багананд металл багана холбосон угсралтын үеийн фото зураг, ил далд ажлын акт, хийцийн зураг төсөл үзэх
 - Шатны хонгил хэсгийн бетон арматурын шинжилгээний дүн мөн металл хийцийн гарал үүсэл хянуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Т ШАЛГА
ГАЗАР

Таламжийг а
улах комисс

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**:

- Барилгын салхивчийг угсарсан ил далд актыг баталгаажуулж шалгуулах
- Дотор халаалтын системийг угсарсан ил далд актыг баталгаажуулж шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**:

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгаа албан бичгээр гаргах
- Халаах хэрэгсэлд хийсэн хамгаалах арга хэмжээг фото зургаар батгалгаажуулж ирүүлэх;

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул Дүүргийн 18 дугаар хороо, Ерөнхий Боловсролын Хобби Сургууль ХХК-ийн захиалгатай 1 давхар нэмэх 31.5м*15.0м, бага ангийн хүүхдийн чийрэгжүүлэх хөгжөөнт тоглоомын танхимын зориулалттай өргөтгөлийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Б.Батчимэг

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга:
Ерөнхий боловсролын Хобби сургууль ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

